


ХИЧЭЭЛ 9

УНШИХ ЗҮЙЛ: ҮЙЛС 27:13-28; ДАГАЛДАГЧДЫН ҮЙЛС, Х. 442-446.

Усан Онгоц Сүйрэв

Та нар өмнө завиар явж үзсэн үү?
Ус тогтуун тайван байсан уу?
Паул болон түүний найзууд усан
онгоцоор явж байгаад хүчтэй
шуургатай учиржээ. Тэгээд
тун аймшигтай зүйл болов.



огшин салхи
исгэрч
хуйлран
байлаа.
Хүчтэй
аадар асарна. Хүчтэй



давалгаа онгоцны хажуугаас цохилно. Усан онгоц тун аюултай дайвалзаж байжээ. Онгоцон дээр байсан хүмүүс бүгдээрээ завь удахгүй сөнөж, хүмүүс живэх байх гэж бодож байсан юм. Харин Паул тэднээс өөр байсан юм.

Паул хүмүүсийн өмнө босож зогслоо. "Өнгөрсөн шөнө Бурхан над руу нэгэн тэнгэр элчээ илгээсэн юм" гэж тэрээр хашгиран хэлэв. "Бүү ай. Бурхан чамтай хамт хөвж яваа бүх хүнийг аврах болно" гэж тэр элч хэллээ.

"Би Бурханд итгэж байна" хэмээн тэрээр тунхаглажээ. "Бүх зүйл Бурханы элчийн хэлсний дагуу болно. Онгоц арал мөргөж сүйрнэ."

Арван дөрөв дэх шөнө далайчид онгоц эх газарт ойртож ирснийг мэдэрчээ. Онгоцоо хадан эрэг мөргүүлэхгүйн тулд тэд зангуугаа буулгав. Хүмүүс өдөр болохыг тэсэн ядан хүлээж байх үед Паул тэдэнд хандан,

Цээжлэх Ишлэл:

"Нэг нэгнийгээ
тайтгаруулж, нэг
нэгнийгээ барьж
байгуулагтун"

1 ТЕСАЛОНИК 5:11.

Тол Санаа:

Бид хүмүүст урам
зориг өгөхдөө
тэдэнд үйлчилж
байдаг.

"Та нар энэ олон өдөр юу ч идсэнгүй. Юм идэцгээ. Та нарт хүч тэнхээ чинь хэрэгтэй. Санагтун, бид бүгдээрээ аврагдана." Дараа нь Паул өөрөө юм идлээ. Хүн бүхэн юм идэв. Одоо тэдний хүч чадал сэргэлээ.

Арайхийн өдөр болтол далайчид хөлгийг эрэг рүү залах гэж оролдсон боловч усан онгоц шууд эрэг рүү явж оров. Дараа нь маш хүчтэй давалгаа ирж усан онгоцыг хажуунаас нь цохьжээ.

Зарим хүмүүс эрэг рүү сэлж эхэлсэн байна. Харин бусад нь сүйрсэн онгоцны сэг хэлтэрхийгээс зуурсаар эрэг рүү хөвлөө. Усан онгоцонд явсан 276 хүн бүгд эсэн мэнд эрэг дээр гарч иржээ.

Арал дээр амьдардаг сайхан сэтгэлтэй олон хүмүүс эрэг рүү хүрч ирж тэдэнд зориулан түүдэг асааж тэднийг дулаацуулав. Паул тэдэнд тусалж түлээ түүж яваад гараа хорт могойнд хатгууллаа. Паул гараа хурдхан сэгсэртэл могой гал руу унажээ. Паулыг удахгүй үхэх байх гэж хүмүүс хүлээж байсан юм. Гэтэл юу ч болсонгүй. Бурхан түүний төлөө санаа тавьжээ.

Арлын ахлагч Публис Паул болон зарим хүмүүсийг тэрээр гэртээ урьж аваачив. Тэрээр тэдний хэрэгцээг анхаарч хангасан байна. Публисын гэрт гурав хоног өнжихдөө Паул түүний аав өвчтэй болохыг мэджээ. Паул гараа түүн дээр тавиад Бурханаас түүнийг эдгээж өгөхийг гуйв. Публисын аав бүрэн эдгэрчээ. Түүнийг эдгэрсэн тухай мэдээ арлаар маш хурдан тархсан юм.

Тэгээд хүмүүс Паул дээр өвчтэй хүмүүсээ авчрав. Паул хүн нэг бүрийн төлөө залбирахад Их Эзэн бүгдийг нь эдгээж өгсөн байна.

Мальта аралд амьдарч байсан сайхан сэтгэлтэй хүмүүс сүйрсэн онгоцны зорчигчдыг асарсныхаа төлөө ивээгдсэн юм. Аялж явсан хүмүүст элэгсэг хандсан арлын оршин суугчдыг Бурхан үнэхээр ивээсэн байна.

Бид ч бас бусдад элэгсэг хандаж чадна. Тусламж хэрэгтэй байгаа хүмүүст бид тусалж Бурханд үйлчилж чадна. Бид бас тэдний төлөө залбирч чадна. Бурхан биднийг ч бас ивээх болно.



Дасгал Ажил

ШАББАТ

Энэ долоо хоногийн өдөр бүр хичээл дээр үзсэн түүхээ хамтдаа уншаад цээжлэх ишлэлээ давтахдаа дараах хөдөлгөөнийг хийгээрэй.

Нэг нэгийгээНэг нэг рүүгээ дараалан тайтгаруулж, заах.

нэг нэгийгээ барьжХоёр гараа зангидаад дээр дээрээс нь тавих.

байгуулагтун.Дээшээ заах.

1 Тесалоник 5:11Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

НЯМ

Шаббат хичээл дээр хийсэн завиа хэн нэгэнтэй хуваалцаж түүний Паул хэрхэн завин дээр байхдаа хүмүүсийг урамшуулж байсан тухай ярихад нь хүүхдээ урамшуулаарай. Эсвэл завь зураарай.

ДАВАА

Үйлс 27:13-28:10-г хамтдаа уншаарай. Асуух: Яагаад завин дээр байсан хүмүүс айж байсан бэ? Паулыг үг хэлсний дараа тэдэнд ямар болсон гэж чи бодож байна? Паул тэдэнд юу гэж хэлсэн бэ? Арал дээр байхдаа Паул өвчтэй хүмүүсийг хэрхэн урамшуулсан бэ? Гэртээ байгаа боолт болон бусад зүйлсийг цуглуураарай. Тэгээд үүгээр өвчтэй хүнийг хэрхэн асрах тухай ярьж өгөөрэй. Хүүхдээрээ өөрийгөө асруулж тоглоорой.

МЯТМАР

Цагаан цуу саван дотор хийнэ үү. Жижиг хуванцар завийг үүн дээр хөвүүл. Дараа нь сод сэгсрэгч



саваар сод завины дээрээс бороо шиг оруулаарай. Сод, цагаан цуу хоёр хэрхэн шуурга үүсгэхийг хамтдаа ажаарай. Паулын завин дээр байсан түүхийг дахин ярьж өгөөрэй. Өнөөдөр аялж байгаа хүмүүсийг эсэн мэнд байлгаж өгөөч гэж залбираарай.

ЛХАТВА

Бусдад урам өгдөг үг хөдөлгөөнийг хүүхдээрээ хэлүүлж, цувруулан бичнэ үү. Хүүхэд тань энэ долоо хоногт урам өгөх ямар нэг зүйл сонсох эсвэл харах болгонд жагсаалтандаа нэмж бичээрэй. Тусламжийн дууг хамтдаа дуулаарай. Дараа нь Урмын үгс хэлдэг байхад маань туслаач гэж Есүсээс гуйгаарай.

ЛҮРЭВ

Бидэнд өдөрт таван жимс эсвэл ногоо хэрэгтэй. Өнөөдөр хэдийг хэрэглэсэн болохыг тоолоорой. Магтаалынхаа цагийн үеэр дөрвөлжин блок ашиглаж, урмын цамхаг байгуулаарай. Тэгэхдээ хэн хэн нь бусдад урмын үг хэлэх болгонд нэг блок нэмэх ёстой.



БААСАН

Библийн түүхийг жүжиглэн тоглоорой. Хүүхдээ нэг хайрцган дотор суулгаад шуурганы үед нааш цааш нь хөдөлгөөрэй. Лхагва гарагаас эхлэн бичсэн урмын үгсийн жагсаалтаа үзээрэй. Тоолно уу. Хэнд хэдэн удаа урмын үг хэлсэн байна вэ?